

Сэтгүүлийн шүүлтийн тогтолцоо

Олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдийн нэгэн адил зохиогчоос шүүгчийнх нь нэрийг нууцладаг системээр бүтээлийг шүүнэ.

- Ерөнхий редактор бүтээлд тавигдах наад захын шаардлага хангагдаагүй гэж үзвэл нийтлүүлэхээр өгсөн бүтээлийг шууд буцааж болно.
- Ерөнхий редактор нийтлүүлэхээр өгсөн бүтээлийг зөвлөлийн гишүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр буцаах шийдвэр гаргаж болно.
- Редакцийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн ажлуудыг тухайн сэдвээр нарийн мэргэшсэн хамгийн багадаа нэг шүүмжлэгч рүү шүүлгэхээр илгээнэ.
- Шүүмжлэгчийг редакцийн зөвлөл хөндлөнгийн оролцоо, нөлөөгүйгээр өөрсдийн бүрэн эрх мэдлийн хүрээнд зөвшилцөн сонгоно.

Судалгааны ажилд тавигдах ерөнхий шаардлага

1. Судалгааны ажлын эхийг Монгол болон Англи хэл дээр өгч болно.
2. Судалгааны ажлын формат нь: мөр хоорондын зай нь 2, фонтны хэмжээ 12, А4-ийн хэмжээтэй, Microsoft word, latex аль алин дээр нь байж болно. Хуудсыг дугаарласан байна. Үгийн тоо 8000-аас хэтрэхгүй.
3. Сэтгүүлд хэвлэгдэхээр шалгарсан ажил latex програм дээр байна.
4. Судалгааны ажлын эхний нүүрэнд дараах мэдээллийг зайлшгүй оруулсан байна. Үүнд: (i) Судалгааны ажлын нэр; (ii) зохиогч, хамтарсан бүтээл бол хамтран зохиогчдын нэр болон харьяа байгууллагын нэр; (iii) хамгийн ихдээ 150 үгэнд багтаасан судалгааны ажлын товчлолыг (абстракт) оруулсан байна. Абстрактыг Англи, Монгол хэл дээр өгнө; (iv) түлхүүр үгсийг JEL кодтой оруулсан байх ; (v) гол холбоо барих зохиогчийн хаяг, талархал, санхүүжүүлэгчийн мэдээлэл зэргийг footnote-р оруулсан байна.
5. Томьёог баруун талд нь (1), (2), гэх мэтээр дугаарласан байна. Ямар нэг томьёоны гаргалгааг товчилж оруулсан бол бүтэн гаргалгааг нь тусдаа хуудсанд оруулсан байвал зохино. Томьёоны гаргалгааг хэвлэх хувилбарт оруулахгүй зөвхөн ажлыг унших шүүгчид ашиглана.
6. Хүснэгт болон графикуудыг тус бүрт нь харгалзах нэртэй нь дугаарласан байна.
7. Текстэн дунд өөр судалгааны ажлаас иш татахдаа зохиогчийн нэр, хаалтан дотор судалгааны ажил хэвлэгдсэн оныг оруулах байдлаар иш татна. Жишээ нь "...Anderson(1972) ажилд..." эсвэл хаалтанд бичих байдлаар "...(e.g., Smith et al., 1969)" гэх мэт. Ашигласан материалын жагсаалтыг гол текстийн ард оруулна. Ашигласан материалын жагсаалтыг доор харуулснаар, Англи хэл дээрх эх сурвалжийн хувьд зохиогчдын овгийн эхний үсгийн, Монгол хэл дээрх эх сурвалжийн хувьд зохиогчдын нэрсийн үсгийн дарааллаар бичнэ.

Л.Баасанжав ба Э.Эрдэнэтуяа, (2011), "Санхүүгийн тайлангийн аудитыг боловсронгуй болгох зарим асуудлууд", Эдийн засаг: онол, практик, №349(26), 101-113.

Lee, D. and C. Kim, (1996), "A Comparison of Industrial and Trade Structures of Korea, Japan and the U.S.," The Korean Economic Review, vol.12, no.1, 135-154.

Anderson, T. W. (1971), The Statistical Analysis of Time Series, New York: John Wiley and Sons.

Wooldridge, J. M. (1994), "Estimation and Inference for Dependent Processes," in R. F. Engle and D. L. McFadden, eds., Handbook of Econometrics, Vol. IV, Amsterdam: Elsevier Science B.V., 2639-2738.

Сэтгүүлийн нэрийг товчлохгүй.

8. Зохиогчид редакцын зөвлөлийн хүсэлтийн дагуу судалгааны ажилд ашигласан тоон өгөгдлөө гаргаж өгнө.

Судалгааны ажлын нүүрний жишээ:

The Colonial Origins of Comparative Development: An Empirical Investigation

By DARON ACEMOGLU, SIMON JOHNSON, AND JAMES A. ROBINSON*

We exploit differences in European mortality rates to estimate the effect of institutions on economic performance. Europeans adopted very different colonization policies in different colonies, with different associated institutions. In places where Europeans faced high mortality rates, they could not settle and were more likely to set up extractive institutions. These institutions persisted to the present. Exploiting differences in European mortality rates as an instrument for current institutions, we estimate large effects of institutions on income per capita. Once the effect of institutions is controlled for, countries in Africa or those closer to the equator do not have lower incomes.

Түлхүүр үгс: Economic growth, Institution, Instrumental variable,

JEL code: O11, P16, P51

* Department of Economics and Business, North Carolina State University, Raleigh, NC 27695, USA and National Statistical Office, 647-15 Yoksam Kangnam, Seoul 135-723, Korea. (e-mail: hjpark@nsohp.nso.go.kr)